

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ
СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.2 дахь хэсгийн "**хувийн ашиг сонирхол** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг" гэснийг "**хувийн ашиг сонирхол** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн, эдийн бус болон **санал худалдан авах ашиг сонирхлыг**" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.6 дахь хэсгийн "**нэгдмэл сонирхолтой этгээд** гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг" гэснийг "**нэгдмэл сонирхолтой этгээд** гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө болон **санал худалдан авах** үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11 дэх хэсгийн "**ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал** гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг" гэснийг "**ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал** гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар болон **санал худалдан авах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг**" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн 48.1.1, 48.1.2, 48.1.3, 48.1.4, 48.1.5, 48.1.8 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн 43.1.1, 43.1.2, 43.1.3, 43.1.4, 43.1.5, 43.1.6 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ___ дугаар
сарын ___ ны өдөр

Улаанбаатар хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн 47.1.1, 47.1.2, 47.1.3, 47.1.4, 47.1.5 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/86¹ дүгээр зүйл. УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах асуудлаар гаргасан Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэх

86^{1.1}. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудлаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороо санал, дүгнэлтийг Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

86^{1.1.1}. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоолыг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

86^{1.1.2}. Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн санал, дүгнэлт Хууль зүй болон Төрийн байгуулалтын байнгын хорооноос гарсан бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан тухайн санал, дүгнэлттэй танилцсаны дараа дүгнэлтийг зөвшөөрөх эсэх асуудлаар хэлэлцэх;

86^{1.1.3}. Нэгдсэн хуралдаанд гишүүд Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх;

86^{1.1.4}. Энэ хуулийн 86^{1.1}-д заасан албан тушаалтан санал хураахын өмнө Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд 5 минутаас илүүгүй, нэгдсэн хуралдаанд 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх;

86^{1.1.5}. Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, ил санал хураалт явуулах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах тухай тогтоолыг хуульд өөрөөр заагаагүй бол ил санал хураалтаар батлах;

86^{1.2} Улсын Их Хурлын даргыг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт гарсан бол нэгдсэн хуралдааныг олонхын бүлгээс сонгогдсон дэд дарга даргалан хуралдуулна.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

22.14 дүгээр зүйл. Санал худалдан авах

1.Санал худалдан авалтын эсрэг хуульд заасан этгээд болон нийтийн албан тушаалтан, иргэн нь санал худалдан авах эсхүл сонгогчдын саналд хууль бусаар нөлөөлөх зорилгоор албан үүрэг, бүрэн эрх, боломж, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Санал худалдан авалтын эсрэг хуулиар хориглосон үйлдлийг хийсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.Сонгуулийн жилд;

2.2.Бүлэглэж;

2.3.Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг дөрвөн жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж, таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 14.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтын “сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч” гэснийг хүчингүй болгосугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тайлбар: Санал худалдан авалтад оролцсон аливаа этгээд өөрийн санаачилгаараа санал худалдан авалтын талаар шүгэл үлээсэн, мэдээлэл, баримт ил тод болгосон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.1-д доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

Эрүүгийн хуулийн 22.14 /Санал худалдан авах/

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

17.3 дүгээр зүйл. Санал худалдах

1.Иргэн нь Санал худалдан авалтын эсрэг хуулийн 11.1.1, 11.1.2-д заасан хориглолтыг зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсгийн 16.1, 16.2, 16.3, 16.4, 16.5 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны __ дугаар
сарын __ ны өдөр

Улаанбаатар хот

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд 4.1.10 гэсэн хэсэг нэмсүгэй:

4.1.10.Улс төрийн нам, эвсэл, харъяа байгууллага, түүний сонгуульт гишүүн;

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санал худалдан авалтын эсрэг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ